



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/251

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Оффис 365 лиценз 250 хэрэглэгч /1 жил/" нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны
дарга:

Г.Цэвээнгэрэл
(Иргэний нисэхийн үндэсний төвийн
Мэдээллийн аюулгүй байдал, технологийн
албаны дарга)

Гишүүд:

Г.Мөнгөлдэй
(Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа
Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны
Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн хэсгийн
дарга)

Х.Мөнхбаяр
("Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл"
Төрийн бус байгууллагын гишүүн
(тохиролцсоноор))

Ш.Нямбаяр
("ХУД Яармаг" Төрийн бус байгууллагын
захирал (тохиролцсоноор))

Нарийн бичгийн
дарга:

Ч.Ганзориг
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Г.Цэвээнгэрэл)-нд, тушаалын хэрэгжилтэд

хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА